

**НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн зөвлөл нь байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.

2. *Сургалт*: БНХАУ болон дэлхий дахинд шинэ коронавирусийн халдвар гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолыг үндэслэн гаргасан Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан сургалт зохион байгуулахыг хориглосон тул албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар сургалтыг 2020 оны 3 дугаар улиралд цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна

3. *Сурталчилгаа*: НМХГ-ын цахим хуудсанд 2020 оны хагас жилийн байдлаар ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлийн мэдээг шинэчлэн байршуулсан.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор уг зөвлөлийн ажиллах журамд тус газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/14 дугаартай тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

2020 оны хагас жилийн байдлаар тус газрын Ёс зүйн зөвлөлд 6 улсын /ахлах/ байцаагчийн ёс зүйтэй холбогдох 3 гомдол, улсын байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн гэх 1 өргөдөл ирснийг 3 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн. Ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон 2 улсын байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай 1 тогтоол, улсын байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн 1 улсын байцаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай 1 тогтоол тус тус гарсан ба 4 улсын /ахлах/ байцаагчид ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй байна. /хүснэгт 1/.

Хүснэгт 1

№	Гомдол гаргасан, иргэн аж ахуйн нэгжийн нэр	Зөрчил гаргасан улсын /ахлах/ байцаагчийн нэр	Гомдлын агуулга	Шийдвэрлэсэн байдал
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд	ХУД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Баянхутаг, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч С.Гантуяа нарын ёс зүйтэй холбоотой асуудал	... Засаг даргын Тамгын газар нь эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрийг аудитын байгууллагаар шалгуулна гэх зэргээр дарамт шахалт үзүүлэн ёс зүйгүй харьцаж, мэргэжилтэнтэй зүй бусаар харьцсан... гэх	2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.

2	Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны иргэн Х.Хадбаатар	СХД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Д.Солонго, Ж.Цэрэнпагма нарын ёс зүйтэй холбоотой асуудал	Миний гаргасан гомдолд холбогдогчид улсын байцаагч гар утас, гэрийн хаяг гэх мэт хувийн мэдээллийг өгсөн... иргэн намайг хэл амаар доромжилсон ... гэх	2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Д.Солонгод “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.д, 3.1.5.а, Ж.Цэрэнпагмад уг дүрмийн 3.1.1.а, 3.1.4.б дахь заалтуудыг үндэслэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.
3	“Эр эм гийх” ХХК	СБД дэх МХХ-ийн Эмчилгээний чанарын улсын байцаагч Ч.Номин, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч З.Ариунтуяа нарын ёс зүйтэй холбоотой асуудал	Эмнэлгийн үйл ажиллагааг хууль бусаар таслан зогсоосон улсын байцаагчийн актыг хүчингүй болгож өгнө үү... гэх	2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
4	БГД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Э.Дуламсүрэн	БГД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Э.Дуламсүрэн улсын байцаагчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн тухай	... улсын байцаагчийн үнэмлэхээ хулгайд алдсан гэх	2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Ёс зүйн зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 3.1.1.а дахь заалтыг үндэслэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх тухай тогтоол /сануулах/ гаргасан.

4. Архив, албан хэрэг хөтлөлт:

Ёс зүйн хорооны 2019 оны хурлын тэмдэглэл, дүгнэлт, үйл ажиллагаатай холбогдолтой тайланг архивын нэгж болгон хавтаслан архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

5. Судалж буй өргөдөл гомдол:

1. Байхгүй.

ХЯНАСАН:
ХЭЗХ-ИЙН ДАРГА

О.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗХ-ИЙН ЭРХ ЗҮЙН
МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЙГАЛМАА